

# 17 дахин

Фермер Жон програмууд их үнэтэй гэдгийг мэдээд, тэр орон нутгийн аж үйлдвэрүүдэд зориулж програм бичдэг жижиг бизнес эхлүүлжээ.

Фермер Жоны анхны програмын ажил түүнд их энгийн санагджээ. Бараг л энгийн. Түүний үйлчлүүлэгч N тоо өгөгдөхөд уг тоог 17-д үржүүлж хэвлэх програм бичүүлэхийг хүсжээ. Фермер Жон энэ энгийн програмыг бичиж дууссан байхад үйлчлүүлэгч түүн рүү залгаж сандарсан байдалтай хэлэхдээ оролт гаралтын тоонууд тус бүрдээ хоёртын тоололд байх бөгөөд тоонууд хэтэрхий том тоо байж болно гэж хэлэв.

Фермер Жонд энэ ажлыг нь дуусгахад нь туслана уу. Оролтын N тоо хоёртын тооллын 1000-аас хэтрэхгүй оронтой тоо өгөгдөхөд уг тоог 17-д үржүүлсэн хоёртын тооллын тоог хэвлэнэ үү.

## Input

Эхний мөр: Хоёртын тооллын N (1000-аас хэтрэхгүй орогтой) тоо.

## Output

Эхний мөр: Хоёртын тооллын  $N * 17$  тоо.

## Example

**Input:**

10110111

**Output:**

110000100111

## Тайлбар:

10110111 тоо нь 10-тын тоололд 183-тай тэнцэнэ.  $183 \times 17 = 3111$  бөгөөд энэ нь 2-тын тоололд 110000100111 гэсэн утга авна.

Орчуулсан : УБ 1-р сургууль Б.Мөнх-Оргил